



БНХАУ-ЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ ТЭРГҮҮТЭЙ ЗОЧИД, ТӨЛӨӨЛӨГЧИД АЛБАН ЁСНЫ АЙЛЧЛАЛ ХИЙНЭ

Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн ерөнхийлөгчийн урилгаар БНХАУ-ын Шинжлэх Ухааны Академи (ШУА)-ийн ерөнхийлөгч, профессор Чунь Ли Бай тэргүүтэй төлөөлөгчид манай улсад энэ оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс 5 дугаар сарын 3-ны өдрүүдэд албан ёсны айлчлал хийнэ. 1999 оны 9 дүгээр сард зохион байгуулсан анхны айлчлалын дараа энэ удаа ийнхүү өргөн бүрэлдэхүүнтэй зочилж байна.

Хятадын ШУА-ийн төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд БНХАУ-ын ШУА-ерөнхийлөгч, профессор Чунь Ли Бай, Хятадын ШУА-ийн Гадаад хамтын ажиллагааг Удирдах газрын ерөнхий захирал, профессор Жин Хуа Цао, Хятадын ШУА-ийн Баруунхойд бүсийн Эко-хүрээлэн буй орчин ба нөөцийн судалгааны хүрээлэнгийн ерөнхий захирал, доктор Ванг Тао, Хятадын ШУА-ийн Нүүрсний

химийн хүрээлэнгийн ерөнхий захирал, профессор Жиан Гуо Ванг, Хятадын ШУА-ийн Гадаад хамтын ажиллагааг Удирдах газрын орлогч захирал Бо Лун Нинг нар багтаж байна.

Энэ удаагийн айлчлалын зорилго нь Монгол, Хятад хоёр орны шинжлэх ухаан, технологийн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх, хамтын ажиллагааны баримт бичгүүдийг шинэчлэн баталгаажуулах, Хятадын Шинжлэх ухаан, технологийн хөгжлийн талаар нээлттэй лекц зохион байгуулах юм.

Айлчлалын хүрээнд Монгол Улсын төр, засгийн байгууллага болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагуудад зочилж, байгалийн шинжлэх ухааны хөгжлийн хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, судалгаа хөгжлийн шинэ чиглэл, боломжийн талаар харилцан санал солилцох юм.

МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ